



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381

Утас/Факс: (976-51) 26 23 50,

Цахим шуудан: info@pcsp.gov.mn,

Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2022.09.16 № А-1/1493

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Чиглэл өгөх тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "...Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана..." гэж заасан болно.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг нарийвчлан судалж, хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг 2022 оны 9 дүгээр сард багтаан цахим хуудсандаа бүрэн байршуулах, өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг шинэчлэн, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээд захирал, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгож байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, тайлан мэдээг холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байхыг үүгээр чиглэл болгож байна.

Заасан хугацаанд мэдээллээ бүрэн байршуулаагүй, мөн хэрэгжилтийг ирүүлээгүй гүйцэтгэх удирдлага болон албан тушаалтанд хариуцлага тооцох болохыг үүгээр мэдэгдье.

Тухайн байгууллагын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хариуцан ажилладаг албан тушаалтны овог, нэр, холбоо барих утасны дугаар, цахим хаягийг 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

*Захирагчид  
Хийгээд  
Хариуцах ажиллагаа  
болмож.*  
Б. Цэнгэл  
2022.09.16

A-4/2022

• 132009538